

ХОРИХ ЯЛ ШИЙТГЭГДСЭН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮҮХДИЙН ЭРХ БА ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧГҮҮД

THE RIGHTS OF CHILDREN OF INCARCERATED WOMEN AND INTERNATIONAL LEGAL INSTRUMENTS

Н.Удвалцэцэг

Дотоод хэргийн их сургуулийн докторант, хошууч

Товч утга: Энэхүү өгүүлэлд хүүхдийн эрхийн талаарх олон улсын эрх зүйн баримт бичгүүдийг тоймлон судалж, хүүхдийн эрхийн конвенц, Бангкокийн дүрэм зэрэг олон улсын баримт бичигт хорих ял шийтгэгдсэн эмэгтэйчүүдийн хүүхдүүдийг тусгай хамгаалалтад хамруулах шаардлагыг хэрхэн тусгасан талаар шинжиллээ.

Мөн Монгол Улсад эдгээр олон улсын гэрээ конвенцын биелэлт, хүүхэд хамгаалал ялангуяа эцэг, эх нь хорих ял шийтгэгдсэн хүүхдүүдийн эрх, хамгаалалтын асуудал холбогдох хууль эрх зүйн акт, бодлогод хэрхэн тусгалаа олж хэрэгжиж байгаа талаар судлан, эдгээр хүүхдүүдийг "эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд" хэмээн ангилж, хамгааллын оновчтой бодлого, үйлчилгээний тогтолцоо бүрдүүлэх шаардлагатайг онцлон дүгнэлээ.

Түлхүүр үгс: Хүүхдийн эрх, эмэгтэй хоригдол, хорих анги, Бангкокийн дүрэм, олон улсын эрх зүйн баримт бичиг, хамгааллын бодлого, Монгол Улс, эрсдэлт нөхцөл.

Abstract: his article reviews key international legal instruments on children's rights, including the Convention on the Rights of the Child and the Bangkok Rules, and analyzes how they address the need for special protection for children of incarcerated women.

It also examines how Mongolia has implemented these international agreements in its national legislation and policies, particularly in relation to the rights and protection of children whose parents are serving prison sentences. The study concludes that these children should be classified as "children in vulnerable situations," and emphasizes the need to establish an effective protection system and targeted policy framework for their support.

Key words: Children's rights, female prisoners, prison, Bangkok Rules, international legal instruments, protection policy, Mongolia, vulnerable situations.

УДИРТГАЛ

Хүүхдийн эрхийг хамгаалах нь хүн бүрийн үүрэг бөгөөд энэ үүргийг хэрэгжүүлэхэд олон улсын болон үндэсний эрх зүйн орчин чухал үүрэгтэй бөгөөд хүүхдийн эрхийн зөрчилд өртөх өндөр эрсдэлтэй бүлгийн нэг нь хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүүхдүүд юм.

Энэ бүлэгт нэг талаас хорих ангид ээжтэйгээ хамт амьдарч байгаа хүүхдүүд нөгөө талаас ээжийгээ хоригдох үед хамаатан садан, асрамжийн газар, эсвэл бие даан амьдрах нөхцөлд үлдсэн хүүхдүүд хамаарна. Тэдний эрх зүйн байдал, хамгаалалт, өсөж бойжих орчин нь нийгмийн зүгээс онцгой анхаарал хандуулах шаардлагатай асуудал болоод байна.

Ямар ч гэмт хэрэг үйлдсэн байсан эмэгтэй хүн үр хүүхэддээ санаа зовж, тэдний сайн сайхны төлөө хичээдэг нь нууцгүй үнэн бөгөөд хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдийн сэтгэл зүйн байдал тогтворгүй болох гол үндсэн шалтгаан нь үр хүүхэд, ар гэртээ санаа зовох явдал юм.

Тэдний үр хүүхэд найдвартай, тайван орчинд, итгэл даахуйц хүний асаргаанд байх нь ээжийн сэтгэл санааг тогтвортой болгож, өөртэйгээ ажиллах, алдсан алдаагаа ухамсарлах, сургалт, сэргээн засах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь хорих байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдахад ч нөлөөлөхүйц чухал нэгэн хүчин зүйл юм.

Хүүхдийн асуудлыг хөндөхдөө “эмэгтэй хоригдлын хүүхэд” гэж тодотгосон шалтгаан нь: Хэдийгээр хорих ял шийтгэгдсэн эрэгтэйчүүд ч мөн адил эцэг хүний хувиар хүүхэдтэй байдаг ч, хүүхдэд хамгийн анхдагч, хүчтэй хамгаалалт, хайр халамжийг үзүүлэгч нь эх хүн юм.

Олон эрдэмтэн, судлаачид эх нь байхгүй үед хүүхэд сэтгэл зүйн гүн хоосрол, итгэл алдрал, нийгмийн тусгаарлалттай нүүр тулгардаг бол, аав байхгүй байсан ч ээжийн халамж, анхаарал дор хүүхэд харьцангуй тайван, хамгаалагдсан нөхцөлд амьдрах боломжтой гэж үзсэн байдаг бөгөөд энэ нь зөвхөн нийгмийн ойлголт биш, биологийн онцлог, хүмүүжлийн нөхцөл, сэтгэл зүйн харилцаанаас шалтгаалдаг онцлогтой.

Их Британийн (Английн) сэтгэл зүйч, сэтгэл заслын эмч, хөгжлийн сэтгэл судлалын анхдагчдын нэг, Бэхэлгээний онолыг үндэслэгч John Bowlby нь өөрийн бүтээлдээ “The child's tie to his mother is a vital element in the development of his personality, and that disruption of this tie may have serious effects” “Хүүхдийн эхтэйгээ тогтоосон холбоо нь түүний хувь

хүний хөгжилд туйлын чухал элемент бөгөөд энэ холбоо тасрах нь ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй." гэж дурьджээ (Bowlby, 1969).

Иймээс энэхүү өгүүлэлдээ хүүхдийн эрхийн олон улсын эрх зүйн үндсийг танилцуулан, Монгол Улсын нөхцөлд эмэгтэй хоригдлын хүүхдийн хамгаалалт, түүний өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудыг тодорхойлохыг зорьлоо.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийг хангах асуудал нь дэлхийн улс орнуудын хувьд нэн тэргүүний зорилтын нэг байсаар ирсэн бөгөөд хүүхэд нас бол хүний амьдралын хамгийн эмзэг, хамгаалалт, анхаарал халамж шаардсан үе тул тэдний амьд явах, сурч боловсрох, хөгжих, хайрлагдах зэрэг үндсэн эрхийг олон улсын түвшинд тусгайлан зохицуулах нь зайлшгүй шаардлагатай юм.

Энэ нь зөвхөн тухайн улс орны дотоод бодлого, хууль эрх зүйн хүрээнд хязгаарлагдахгүй, харин дэлхий нийтийн хамтын хүчин чармайлт, хариуцлагын асуудал болж хөгжсөөр иржээ.

Олон улсын эрх зүйн баримт бичгүүдийн тойм

Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын эрх зүйн үндэс нь дараах хэд хэдэн чухал баримт бичиг дээр суурилна. Үүнд:

1. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (CRC, 1989)

Энэхүү конвенц нь хүүхдийн амьд явах, хөгжих, хамгаалуулах, оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, гэр бүлийн орчныг дэмжих, ялгаварлан гадуурхахгүй байх, хүүхдийн дээд ашиг сонирхлыг тэргүүнд тавих зэрэг 54 зүйл бүхий иж бүрэн, суурь эрх зүйн баримт бичиг юм. Монгол Улс 1990 онд уг конвенцид нэгдэн орсон бөгөөд 1992 онд хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн (конвенц Х. э., 1989).

2. Хүүхдийн эрхийн тухай нэмэлт протоколууд

1-р протокол: Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд ашиглахын эсрэг- Монгол Улс 2000 онд гарын үсэг зурж, 2002 онд соёрхон баталсан. (протоколууд, 2002)

2-р протокол: Хүүхдийн худалдаа, бэлгийн мөлжлөг, порнографийн эсрэг. Монгол Улс 2003 онд соёрхон баталсан.

3-р протокол: Хүүхэд гомдол гаргах механизм (Optional Protocol 3). Монгол Улс хараахан нэгдээгүй.

3. CEDAW – Эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн ялгаварлалтай тэмцэх конвенц (1979)

Энэхүү конвенцид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх тэгш байдал, түүний дотор эмэгтэйчүүдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, ял шийтгэгдсэн эмэгтэйчүүдийн эрх зэрэг багтах бөгөөд хүүхдийн эрхийг шууд зохицуулдаггүй ч эмэгтэйчүүдийн эх болох, хүүхэд асрах эрх, гэр бүлийн хүрээн дэх хамгаалалтад онцгой анхаардаг.

Иймд эмэгтэй хоригдлын хүүхдүүдийн асуудлыг уг конвенцын хүрээнд авч үзэх боломжтой юм. Уг конвенцид Монгол Улс 1981 онд нэгдэн орж, НҮБ-д тайланг хүргүүлэх замаар хэрэгжилтийг хангаж байна. (конвенц э. а., 1979)

4. Бангкокийн дүрэм (2010)

Уг дүрмийг 2010 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан бөгөөд эмэгтэй хоригдлуудыг эмчлэх болон эмэгтэй гэмт хэрэгтнүүдэд хорихоос өөр төрлийн арга хэмжээ авах, эмэгтэй хоригдлуудын тусгай хэрэгцээ, нөхцөл байдалд нийцсэн олон улсын анхны стандарт бөгөөд нийт 70 заалттай. Монгол Улс нь НҮБ-ын гишүүн орны хувьд Бангкокийн дүрмийг дэмжиж, хэрэгжилтийг хангах үүрэгтэй. (Bangkok, 2023)

5. Хөдөлмөрийн олон улсын байгууллагын (ILO) хүүхдийн хөдөлмөрийн талаарх конвенцууд

ILO-138 – Хамгийн бага хөдөлмөр эрхлэх насыг заах тухай

ILO-182 – Хүүхдийн хөдөлмөрийн хамгийн хүнд хэлбэрийг хориглох тухай

Монгол Улс эдгээрт нэгдсэн бөгөөд хүүхдийн хүчээр хөдөлмөрлөх, мөлжлөгт өртөхөөс хамгаалах хууль зүйн үндэс болдог.

6. Хүүхдийн эрхийн тухай Ерөнхий тайлбарууд (CRC committee’s General Comments):

Энэхүү баримт бичгүүд нь хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтийг тайлбарлаж, гишүүн улсуудад хэрэгжилтийг нь уялдуулах зорилгоор конвенцын заалтуудыг гүнзгий тайлбарлаж, улс орнууд бодлого, хууль, практикт хэрхэн тусгах ёстой талаар чиглэл өгдөг НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос гаргасан маш чухал баримт бичгүүд юм.

Ерөнхий тайлбар №7 (2005): “Хүүхдийн эрт үеийн хөгжил”

Энэхүү тайлбар нь 0–8 насны хүүхдийг бие даасан эрхийн эзэн гэж үзэн, тэдний бие бялдар, сэтгэл зүй, нийгмийн хөгжилд анхаарах шаардлагатайг онцолж, төр, эцэг эх, нийгмийн зүгээс эрүүл, аюулгүй, хайр халамжтай орчин бүрдүүлэх нь чухал бөгөөд эрт үеийн боловсрол, хамгаалалт, хоол тэжээл, гэр бүлийн орчны чанар нь хүүхдийн цаашдын хөгжлийн үндэс болдог гэсэн ерөнхий агуулгатай.

Агуулгын хүрээнд улс орнуудад эрт насны хүүхдүүдэд зориулсан нийтийн болон хүртээмжтэй эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ хөгжүүлэх, хүүхэд бүрийн хөгжилд эерэг орчин бүрдүүлэх, хүчирхийллээс ангид орчинг дэмжих, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн хөгжилд чухал үүрэгтэйг ойлгуулах, дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгтэй гэж зөвлөн тайлбарладаг.

Ерөнхий тайлбар №9 (2006): “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх”

Энэхүү тайлбар нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн хүүхдүүдтэй адил ижил эрх эдлэх ёстой бөгөөд тэдний нэгдмэл, хүртээмжтэй оролцоог хангах нь зөвхөн халамж бус хүний эрхийн асуудал гэж үзэн, ялгаварлан гадуурхахгүй байх, оролцоо, хүртээмж, хөгжлийн боломжийг гол тулгуур зарчмаа болгодог.

Бусад улс орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгайлан чиглэсэн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ бий болгох, хүүхдийг гэр бүлд нь, эсвэл нийгэмд оролцоотой амьдруулах орчныг бүрдүүлэх, ялангуяа асрамж, тусгай байгууллагад өсч буй хүүхдүүдийн амьдрах орчин, халамжийн чанар, хамгаалалтад онцгой анхаарах хэрэгтэй гэж зөвлөн тайлбарладаг.

Ерөнхий тайлбар №13 (2011): “Хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах”

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл (бие махбод, сэтгэл зүй, бэлгийн хүчирхийлэл, хайхрамжгүй байдал, дарамт гэх мэт) нь зөвхөн гэр бүлийн хүрээнд биш, бүх орчинд тохиолдож болдог бөгөөд төр хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох, нөхөн сэргээх бүрэн үүрэгтэй гэсэн агуулгатай.

Бусад улс орнуудад хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй нэгдсэн байдлаар тэмцэх хууль тогтоомж, бодлогын тогтолцоо бий болгох, мэдээлэх, хамгаалах, сэргээн засах механизмуудыг хүртээмжтэй болгох,

хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэг үзүүлэх систем бий болгох хэрэгтэй гэж зөвлөн тайлбарладаг.

Эдгээр ерөнхий тайлбарууд нь улс орнуудын хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний бодлого, хууль тогтоомж, үйлчилгээний хүртээмж, чанар зэргийг сайжруулахад практик удирдамж болох чухал баримт бичгүүд юм.

Дээрх олон улсын баримт бичгүүдэд эх нь хорих ялаар шийтгэгдэх үед хамаатан садан, асрамжийн газар, хараа хяналтгүй үлдсэн хүүхдүүд болон эхийн хамт хорих ангид байгаа хүүхдүүдийн эрхийг хамгаалах заалтууд дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

1. Хүүхдийн эрхийн тухай конвенц (CRC, 1989)

3 дугаар зүйл: “Хүүхдийн хамгийн сайн ашиг сонирхлыг эрхэмлэн үзнэ (конвенц Х. э., 1989).”

Тайлбар- Хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах зарчим бол хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын болон үндэсний эрх зүйн чухал тулгуур юм. Ямар нэгэн шийдвэр гаргахдаа зөвхөн насанд хүрэгчдийн ашиг сонирхлыг бус, хамгийн түрүүнд хүүхдэд хэрхэн нөлөөлөхийг бодолцох үүрэгтэй гэсэн санааг илэрхийлнэ.

9 дүгээр зүйл: “Хүүхэд эцэг, эхээсээ тусгаарлагдах ёсгүй. Тусгаарлагдах шаардлагатай бол хүүхдэд сөрөг үр дагавар багатай байх нөхцөлийг бүрдүүлэх ёстой.” (конвенц Х. э., 1989)

Тайлбар- Энэ нь эцэг, эх нь хорих ялаар шийтгэгдсэн үед хүүхдийн байх нөхцөлийг хамгийн сайнаар шийдэх ёстойг анхаарах заалт юм.

2. Бангкокийн дүрэм (Bangkok, 2023)

49 дүгээр заалт: “Эмэгтэй хоригдлын асрамжинд байгаа хүүхдүүдийн хэрэгцээг үнэлж, зохих орон байраар хангах, хамгааллын тусгай арга хэмжээг хэрэгжүүлнэ.”

50 дугаар заалт: “Ээжтэйгээ хорих ангид хамт байгаа хүүхдүүдэд тэдний хөгжил, эрүүл мэндэд нийцсэн орчин нөхцөлийг бүрдүүлнэ.”

51 дүгээр заалт: “Хүүхдийг хорих ангид хамт байлгах эсэх талаар шийдвэр гаргахдаа тухайн хүүхдийн ашиг сонирхол, сэтгэл зүйн байдал, ээжийн нөхцөл байдлыг үнэлнэ.”

3. Хүүхдийн эрхийн тухай хорооны Ерөнхий Тайлбар №10 (10, 2025)

44-р хэсэг: “Эцэг, эх нь хоригдож байгаагаас үүдсэн хүүхдийн хүнд нөхцөл байдалд тусгайлан анхаарах шаардлагатай. Тэднийг тусгаарлаж, сэтгэл зүйн дарамтад оруулахгүй байх нөхцөл бүрдүүлэх хэрэгтэй.” гэж тус тус заажээ

Монгол Улсын нөхцөл

Монгол Улсад эцэг, эх нь хорих ял эдэлж буй, эсвэл эхийн хамт хорих ангийн байрлалд амьдарч буй хүүхдийн эрхийн талаар тодорхой тусгасан хууль, журам, цогц зохицуулалт дутмаг байна. Хүүхдийн эрхийн тухай болон Гэр бүлийн тухай хуульд нийтлэг хүүхдийн эрхийг хангах зарчмууд тусгасан ч, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийн эрхийг нарийвчлан зохицуулаагүй.

Зөвхөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ял эдэлж байх хугацаандаа хүүхэд төрүүлсэн хоригдлыг хүүхдийг нь хоёр нас хүртэл хамт байлгаж болох ба тухайн эмэгтэйн ял эдлэх үлдэгдэл хугацаа 1 жилээс илүүгүй тохиолдолд хорих ял эдлэх хугацааг дуусах хүртэл хүүхдийг үргэлжлүүлэн хамт байлгаж болно.

Мөн тухайн хорих анги нь “эхийн хамт байгаа хоёр хүртэлх насны хүүхдийг эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинг бүрдүүлсэн тусгай байр, нөхцөлөөр хангана” (хууль Ш. ш., 2025) гэж заажээ.

Үүнээс гадна Хүүхдийн эрхийн тухай хуульд “эрсдэлт нөхцөл” (хууль Х. э., 2025) гэдэг нэр томъёог тусгасан байгаа боловч энэ эрсдэлт нөхцөл гэж ямар нөхцлийг ойлгох, хэрхэн илрүүлэх, цаашлаад ямар арга хэмжээ авах талаар дэлгэрэнгүй зохицуулалт тусгагдаагүй байна.

Дээрхээс харахад Монгол Улсад эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийн эрхийг хамгаалах, ийм нөхцөлд хүүхдүүд байгаа гэдгийг илэрхийлж, тэдэнд чиглэсэн цогц бодлого, хууль эрх зүйн зохицуулалт хангалтгүй бөгөөд одоо хэрэгжиж буй хууль журамд нэг өгүүлбэр ч тусгагдаагүй гэхэд хилсдэхгүй бизээ. Ингэж зайлшгүй хамгаалалт, хараа хяналт, дэмжлэг шаардлагатай харилцааг орхигдуулснаар энэ нь өөрөө хүүхдийн эрхийг зөрчих нөхцлийг бүрдүүлж байгаагийн нэг хэлбэр юм.

ДҮГНЭЛТ

Хорих ял шийтгэгдсэн эмэгтэйчүүдийн хүүхдүүдийн эрхийн асуудал нь Монгол Улсад төдийгүй олон улсын хэмжээнд орхигдсон, эмзэг, тусгай анхаарал шаардсан сэдэв байсаар байна.

Хүүхдийн эрхийн тухай олон улсын гол баримт бичгүүд, тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Бангкокын дүрэм, ерөнхий тайлбарууд нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хамгаалалт, халамжийг тэгш хүртэх эрхийг онцолж, эмэгтэй хоригдлын хамт хорих ангийн орчинд амьдарч буй эсвэл асрамж, хамгаалалтгүй үлдсэн хүүхдүүдэд тусгай анхаарал хандуулахыг шаардаж байна.

Монгол Улс нь НҮБ-ын гишүүн орон бөгөөд Хүүхдийн эрхийн тухай конвенц болон холбогдох олон улсын баримт бичгүүдэд нэгдэн орж, хүүхдийн эрхийг хамгаалах үүрэг хүлээсэн хэдий ч, эдгээр хүүхдүүдийн асуудалд хангалттай анхаарал хандуулахгүй, тэдний эрх, хамгаалал орхигдож, олон улсын өмнө хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгааг анзаарах шаардлагатай бөгөөд эдгээр хүүхдүүд нийгмийн хамгааллын тогтолцоонд бүрэн хамрагдаж чадахгүй, хөсөр хаягдаж буй эмзэг бүлгийн нэг хэсэг болоод байгаа нь харамсалтай.

Тиймээс эдгээр хүүхдүүдийн тусгай хэрэгцээ, сэтгэлзүйн байдал, амьдрах орчны шаардлагыг харгалзан үзсэн, хамгаалал, халамжийн уялдаа холбоотой тогтолцоог бий болгох нь нэн тэргүүний шаардлагатай асуудал юм.

САНАЛ

1. Хууль, бодлогын шинэчлэлийн хүрээнд.

Эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр Хүүхдийн эрхийг тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Нийгмийн хамгааллын бодлого зэрэгт нэмэлт, өөрчлөлт оруулж, тусгай зохицуулалтуудыг оруулах.

Хорих ангийн байрлалд ээжтэйгээ хамт байгаа хүүхдүүдийн эрхийг хангах, эхийн үүрэг хариуцлагыг нарийвчлан тодорхойлох, тэдний бүхий л харилцаа, тухайн байрны үйл ажиллагааг зохицуулах тусгайлсан журам боловсруулан мөрдөх.

2. Нийгмийн хамгааллын тогтолцоонд хамруулах

Эдгээр хүүхдүүдийг нийгмийн хамгааллын тогтолцооны “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн ангилалд хамруулж, тэдэнд зориулсан

тусгай халамж, үйлчилгээ, тэтгэлэг, сэтгэлзүйн болон боловсролын дэмжлэг үзүүлэх механизм бий болгох.

3. Хорих ангийн нөхцөлийг сайжруулах

Эхийн хамт байгаа хүүхдүүдийн амьдрах орчны эрүүл, аюулгүй байдлыг хангах, тэдний насны онцлогт тохирсон эрүүл мэнд, сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх орчин, хүүхэд асаргааны мэргэжлийн алба бүрдүүлэх.

Эхийн хамт байгаа хүүхдүүдэд зарцуулагдах төсөв, хөрөнгийг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлэн, хорих ангийн жилийн төсөвт суулгах.

4. Салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжих

Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурласан цогц хамгааллын тогтолцоо бий болгох.

5. Судалгаа, мэдээлэлд суурилсан бодлого боловсруулах

Эдгээр хүүхдүүдийн бодит нөхцөл байдлын талаарх статистик, судалгаа, баримт мэдээллийг цуглуулах, бодлого боловсруулалтад ашиглах тогтолцоог бэхжүүлэх .

6. Олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх

Хүүхдийг гэм буруугүй орших субъект гэж ойлгуулж, эцэг, эхийн үйлдэл, ял шийтгэлээс ангид, тэдний эрхийг хамгаалах талаар олон нийтэд чиглэсэн **сургалт, мэдээлэл** тогтмол явуулах.

Эх сурвалж

- 10, G. C. (2025, 05 31). *www.ohchr.org*. Retrieved from <https://www.ohchr.org/english/bodies/crc/docs/CRC.C.GC.10.pdf>.
Bangkok, r. (2023, 09 23). *www.ohchr.org*. Retrieved from <https://www.penalreform.org/resource/guidance-document-on-the-bangkok-rules/>.
конвенц, Х. э. (n.d.). *Legalinfo.mn*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/1276>.
хууль, Х. э. (2025, 05 31). *legalinfo.mn*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11709>.
хууль, III. ш. (2025, 05 31). *legalinfo.mn*.